



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

21000. Дорнод аймаг, Хэрэг сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.08.14 № 581

танай _____ -ны № _____ -т

**ДОРНОД АЙМГИЙН ГУРВАНЗАГАЛ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ГУРВАНЗАГАЛ
СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ДАРГА
Д.ЭРДЭНЭБААТАР ТАНАА**

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Гурванзагал сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Гурванзагал сумын Монгол ардын нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Гурванзагал сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

“Гурванзагал сумын Монгол ардын нам”-ын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцоо ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Гурванзагал сумын Монгол ардын нам”-ын мөрийн хөтөлбөр /.... хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Дорнод аймгийн сонгуулийн хороонд


Хавсралт хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

Дорнод аймгийн Гурванзагал сумны
Монгол Ардын Намын хорооны Тэргүүлэгчдийн
2020 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн
01/р хуралдааны 02 тоот тогтоолын хавсралт



**ДОРНОД АЙМГИЙН ГУРВАНЗАГАЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН
НАМЫН ХОРООНЫ 2020 ОНЫ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

ГУРВАНЗАГАЛ СУМ

1. Нийгмийн салбарт

- 1.1 ЕБС-ийн өргөтгөл барих.
- 1.2 Сумын төвийн цахилгаан дамжуулах агаарын шугамыг шат дараалалтайгаар шинэчилнэ.
- 1.3 Сумын төвийн хорооллуудын гудамжны гадна гэрэлтүүлгийг үе шаттайгаар гэрэлтүүлэх.

2. Эрүүл мэндийн салбарт

- 2.1 Уламжлалт анааах ухааны эмчилгээг өргөтгөх.
- 2.2 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэх зан үйлийг төлөвшүүлэх, бодлогыг дэмжиж ажиллах
- 2.3 Ахмад настан, хүүхдийг эмчлүүлэх таатай орчин нөхцлийг бүрдүүлэхийн зэрэгцээ хүн эмнэлгийг түшиглэн суурь өвчтэй хүүхдийг сувилан эрүүлжүүлэх сувилал байгуулна.
ЖСДА0056 9030891 44066
- 2.4 Эрүүл шүд-эрүүл хүүхэд хөтөлбөрийг дэмжин ажиллах

3. Боловсрол, Соёл урлаг

- 3.1 Сургуулийн барилгад өргөтгөл барих.
- 3.2 Соёл урлагын салбарын хөгжлийг дэмжих, өв соёл, сумын дэд хөтөлбөрийг дэмжин ажиллах
- 3.3 Орон нутгийн номын сангийн уламжлалт үйлчилгээг чанаржуулах, номын баяжилт хийх.


4. Хөдөө аж ахуй

- 4.1 Бүх багуудад ундны усны худаг гаргах, малчдын санал, хүсэлт, иргэдийн оролцоонд тулгуурлан гүний худгуудыг гаргах, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх.
- 4.2 Малжуулах төсөл хэрэгжүүлэх /Хөдөөгийн багийн болон төрийн албан хаагчид өрхүн орлого бага иргэд малчид/
- 4.3 Хөдөө аж ахуйг хөгжүүлэх төмс хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэх, Сумын төвийн өрхүүдийг бодлогоор дэмжиж Хүлэмж аж ахуй байгуулах
- 4.5 Өвсний нөөцийн агуулахыг бүх багт байгуулна.
- 4.6 Малын үүлдвэр угсааг сайжруулах, эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх үйл ажиллагааг бодлогоор дэмжин хөгжүүлэх
- 4.7 Мал эрүүлжүүлэх, мал эмнэлгийн үйл ажиллагааг сайжруулах

4.8 Арьс, шир ,Сүү боловсруулах цех байгуула

5.Байгаль орчин

- 5.1 Ховордож байхгүй болж буй тарвагийг эргэн нутагшуулах**
- 5.2 Цагаан зээр болон бусад ховор ан амьтанг хамгаалах**
- 5.3 Булаг шандын эхийг хашаажуулж хамгаалах**



**ГУРВАНЗАГАЛ СҮМҮН МОНГОЛ АРДЫН
НАМЫН ХОРОО**